



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2024/240-НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Б.Ундаръяа Утас: 70376994 Цахим хаяг: <a href="mailto:unddariya11@gmail.com">unddariya11@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	15
3.5.3 Нэмэлт төсөв .....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
5.1 Албан шаардлага.....	20
5.1 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГБХН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

САНТ СУМЫН  
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Л.ХҮРЭЛМАА ТАНАА

2024.02.23 № СНА-2024/240/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 6,980.0 мянган төгрөгийн 2 дугаар хоолны тогоо худалдан авч, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 9,836.0 мянган төгрөгийн 1 дүгээр хоолны тогоог үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

## **Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>57,166,036.11</b>	<b>149,824,550.62</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>21,853,048.11</b>	<b>107,136,503.62</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>21,853,048.11</b>	<b>107,136,503.62</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>21,853,048.11</b>	<b>107,136,503.62</b>
31211	Төрийн сангийн харилцах	21,853,048.11	107,136,503.62
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>35,312,988.00</b>	<b>42,688,047.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>35,312,988.00</b>	<b>42,688,047.00</b>
35410	Бичиг хэргийн материал	103,500.00	0.00
35460	Хүнсний материал	3,952,145.00	2,783,272.00
35470	Бусад хангамжийн материал	31,257,343.00	39,904,775.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>282,800,738.30</b>	<b>278,247,409.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>282,800,738.30</b>	<b>278,247,409.75</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>267,515,804.86</b>	<b>263,212,476.27</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	286,738,600.00	286,738,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,964,079.20)	(59,955,099.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	44,963,515.00	54,994,115.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,093,635.46)	(29,432,639.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,179,050.00	17,179,050.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,257,340.19)	(13,104,465.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,669,300.00	14,669,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,569,605.290)	(8,726,385.45)
39217	Ном	850,000.00	850,000.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>15,284,933.44</b>	<b>15,034,933.48</b>
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(666,666.56)	(916,666.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,701,600.00	14,701,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>339,966,774.41</b>	<b>428,071,960.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,847,650.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,847,650.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>1,847,650.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	1,847,650.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>339,966,774.41</b>	<b>426,224,310.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>339,966,774.41</b>	<b>426,224,310.37</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	145,152,995.00	145,152,995.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	145,152,995.00	145,152,995.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>194,813,779.41</b>	<b>281,071,315.37</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(145,871,995.00)	194,813,779.41
51220	Тайлант үеийн үр дүн	340,685,774.41	86,257,535.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>339,966,774.41</b>	<b>428,071,960.37</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>703,473,881.60</b>	<b>531,947,090.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>334,926,570.15</b>	<b>25,022,050.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>334,926,570.15</b>	<b>25,022,050.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>7,015,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,015,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	302,801,126.35	9,836,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	32,125,443.80	8,171,050.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>368,547,311.45</b>	<b>506,925,040.45</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>324,386,600.00</b>	<b>466,632,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	324,386,600.00	466,632,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>44,160,711.45</b>	<b>40,292,940.45</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,160,711.45	40,292,940.45
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>362,788,107.19</b>	<b>445,689,554.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>362,788,107.19</b>	<b>445,689,554.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>362,788,107.19</b>	<b>445,689,554.49</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>249,936,940.61</b>	<b>298,195,502.43</b>
210101	Үндсэн цалин	188,928,576.75	217,078,512.59
210102	Нэмэгдэл	49,551,067.86	70,939,336.16
210104	Урамшуулал	11,457,296.00	10,177,653.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,451,681.17</b>	<b>38,764,028.56</b>

210201	Тэтгэврийн даатгал	21,384,542.44	26,688,778.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,516,782.71	3,118,930.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,013,427.75	2,392,333.81
210204	Ажилгүйдлийн даатгал	503,356.96	583,151.69
210205	Эрүүл мэндийн даатгал	5,033,571.31	5,980,834.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,089,862.56</b>	<b>36,677,940.45</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,541,516.16	8,658,172.86
210302	Түлш, халаалт	21,341,346.40	27,743,667.59
210303	Цэвэр, бохир ус	207,000.00	276,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>120,000.00</b>	<b>2,638,618.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,638,618.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,822,357.80</b>	<b>31,651,186.50</b>
210502	Хоол, хүнс	23,822,357.80	31,651,186.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>496,100.00</b>	<b>3,518,200.00</b>
210604	Урсгал засвар	496,100.00	3,518,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>528,000.00</b>	<b>720,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	528,000.00	720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,343,165.05</b>	<b>33,524,078.55</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,914,000.28	9,979,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,427,776.72	2,175,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,001,388.05	21,369,328.55
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>340,685,774.41</b>	<b>86,257,535.96</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>340,685,774.41</b>	<b>86,257,535.96</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>368,547,311.45</b>	<b>513,940,040.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>7,015,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>7,015,000.00</b>

<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>7,015,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,015,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>368,547,311.45</b>	<b>506,925,040.45</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>324,386,600.00</b>	<b>466,632,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	324,386,600.00	466,632,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>44,160,711.45</b>	<b>40,292,940.45</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,160,711.45	40,292,940.45
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>346,694,263.34</b>	<b>421,676,584.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>346,694,263.34</b>	<b>421,676,584.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>346,694,263.34</b>	<b>421,676,584.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>249,936,940.61</b>	<b>298,195,502.43</b>
210101	Үндсэн цалин	188,928,576.75	217,078,512.59
210102	Нэмэгдэл	49,551,067.86	70,939,336.16
210104	Урамшуулал	11,457,296.00	10,177,653.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,451,681.17</b>	<b>38,764,028.56</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,384,542.44	26,688,778.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,516,782.71	3,118,930.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,013,427.75	2,392,333.81
210204	Ажилгүйдлийн даатгал	503,356.96	583,151.69
210205	Эрүүл мэндийн даатгал	5,033,571.31	5,980,834.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,089,862.56</b>	<b>36,822,940.45</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,541,516.16	8,803,172.86
210302	Түлш, халаалт	21,341,346.40	27,743,667.59
210303	Цэвэр, бохир ус	207,000.00	276,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>120,000.00</b>	<b>0.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,827,902.00</b>	<b>30,362,813.50</b>
210502	Хоол, хүнс	25,827,902.00	30,362,813.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>496,100.00</b>	<b>3,470,000.00</b>
210604	Урсгал засвар	496,100.00	3,470,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>528,000.00</b>	<b>720,000.00</b>

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	528,000.00	720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,243,777.00</b>	<b>13,341,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,043,800.00	11,165,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,199,977.00	2,176,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>21,853,048.11</b>	<b>92,263,455.51</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>6,980,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>6,980,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>6,980,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	6,980,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>(6,980,000.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>21,853,048.11</b>	<b>85,283,455.51</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,853,048.11	107,136,503.62

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	145,152,995.00	0.00	(145,871,995.00)	(719,000.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	145,152,995.00	0.00	(145,871,995.00)	(719,000.00)
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	340,685,774.41	340,685,774.41
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,152,995.00	0.00	194,813,779.41	339,966,774.41

11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	145,152,995.00	0.00	194,813,779.41	339,966,774.41
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	145,152,995.00	0.00	194,813,779.41	339,966,774.41
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	86,257,535.96	86,257,535.96
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,152,995.00	0.00	281,071,315.37	426,224,310.37

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>535,793,140.45</b>	<b>428,656,584.94</b>	<b>107,136,555.51</b>	80.0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>535,793,140.45</b>	<b>428,656,584.94</b>	<b>107,136,555.51</b>	80.0
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>535,793,140.45</b>	<b>428,656,584.94</b>	<b>107,136,555.51</b>	80.0
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>380,433,700.00</b>	<b>298,195,502.43</b>	<b>82,238,197.57</b>	78.4
210101	Үндсэн цалин	252,678,240.45	217,078,512.59	<b>35,599,727.86</b>	85.9
210102	Нэмэгдэл	114,759,600.00	70,939,336.16	<b>43,820,263.84</b>	61.8
210104	Урамшуулал	11,762,700.00	10,177,653.68	<b>1,585,046.32</b>	86.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,539,300.00</b>	<b>38,764,028.56</b>	<b>13,775,271.44</b>	73.8
210201	Тэтгэврийн даатгал	35,727,200.00	26,688,778.36	<b>9,038,421.64</b>	74.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,202,700.00	3,118,930.00	<b>1,083,770.00</b>	74.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,362,000.00	2,392,333.81	<b>969,666.19</b>	71.2
210204	Ажилгүйдлийн даатгал	841,300.00	583,151.69	<b>258,148.31</b>	69.3
210205	Эрүүл мэндийн даатгал	8,406,100.00	5,980,834.70	<b>2,425,265.30</b>	71.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,822,940.45</b>	<b>36,822,940.45</b>	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,803,172.86	8,803,172.86	-	100.0
210302	Түлш, халаалт	27,743,667.59	27,743,667.59	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	276,100.00	276,100.00	-	100.0

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,384,600.00</b>	<b>30,362,813.50</b>	<b>11,021,786.50</b>	73.4
210502	Хоол, хүнс	41,384,600.00	30,362,813.50	<b>11,021,786.50</b>	73.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,450,000.00</b>	<b>10,450,000.00</b>	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,980,000.00	6,980,000.00	-	100.0
210,604.00	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>725,300.00</b>	<b>720,000.00</b>	<b>5,300.00</b>	99.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	725,300.00	720,000.00	<b>5,300.00</b>	99.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,437,300.00</b>	<b>13,341,300.00</b>	<b>96,000.00</b>	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,261,300.00	11,165,300.00	<b>96,000.00</b>	99.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,176,000.00	2,176,000.00	-	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>535,793,140.45</b>	<b>513,940,040.45</b>	<b>21,853,100.00</b>	95.9
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>466,632,100.00</b>	<b>466,632,100.00</b>	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	466,632,100.00	466,632,100.00	-	100.0
	Орон нутгийн төсөөс	40,292,940.45	40,292,940.45		
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>28,868,100.00</b>	<b>7,015,000.00</b>	<b>21,853,100.00</b>	24.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,015,000.00	7,015,000.00	-	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,853,100.00	0.00	<b>21,853,100.00</b>	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	21,853,048.11	<b>(21,853,048.11)</b>	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	107,136,503.62	<b>(107,136,503.62)</b>	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сант сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхэд бүр оюун ухаан, сэтгэлээрээ эрүүл өсөн бойжих, өөрийн онцлог бүтээлч үйлээрээ хөгжих, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд хүүхэд нэг бүрд дэмжлэг үзүүлэх, сургуульд бэлтгэх, СӨБ-ын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамран сургах боломжийг бий болгох
- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, 5 настай хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах
- Сургалтын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, багшийн ажлын гүйцэтгэлд суурилан байгууллага болон багшийн хөгжлийг дэмжих уян хатан, олон хэлбэрт сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, байгууллагын үйлчилгээний чанарт ахиц гаргах
- Боловсролын байгууллагын багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг эрхэмлэн баг, хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх санал санаачилгыг дэмжих, манлайлах, үр дүнг тооцох
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх зохистой дадал хэвшилд сургах, сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Цэцэрлэгийн нэг хүүхдэд улсын төсвөөс олгох хувьсах зардлын санхүүжилтийг зориулалтын дагуу хамт олны оролцоотой төлөвлөж хэрэгжилтийг үр дүнтэй нээлттэй ил тод байдлыг хангах
- Сургалтын байгууллага хоорондын хамтран ажиллах чадавхыг бэхжүүлэх цэцэрлэг сургуульд суурилсан менежментийг сайжруулахад мэргэжлийн холбоо, эцэг эх асран хамгаалагч олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэгдэн батлагдсан
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,105.2 мянган төгрөгөөр буюу 20.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,853.00	107,136.50	85,283.50
Авлага	-	-	-
Бараа материал	35,313.00	42,688.00	7,375.00
Үндсэн хөрөнгө	282,800.70	278,247.40	(4,553.30)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>339,966.70</b>	<b>428,071.90</b>	<b>88,105.20</b>
Өр төлбөр	-	1,847.60	1,847.60
Засгийн газрын хувь оролцоо Эздийн өмч/	339,966.70	426,224.30	86,257.60
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>339,966.70</b>	<b>428,071.90</b>	<b>88,105.20</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 107,136.5 мянган төгрөг болж 85,283.5 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9<sup>1</sup>-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,

<sup>1</sup> Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

- Бараа материалын дансны үлдэгдэл 42,688.0 мянган төгрөг болж 7,375.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 44,555.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, “Сант хөгжлийн хөтөч” ТББ-аас 7,650.0 мянган төгрөгийн тоглоом, эд хогшил, Дэлхийн зөн ОУБ-аас 407.6 мянган төгрөгийн галын хэрэгсэл, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 92.0 мянган төгрөгийн хоолны сав, тооллогоор илэрсэн 21.5 мянган төгрөгийн хүнсний материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, нийт 45,351.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 278,247.4 мянган төгрөг болж 4,553.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,980.0 мянган төгрөгийн 2 дугаар хоолны тогоо худалдан авч, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 9,836.0 мянган төгрөгийн 1 дүгээр хоолны тогоо, будаа агшаагч, битүү чанагч зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, сумын ИТХ-ын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор 6,785.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж данснаас хассан, 14,583.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,847.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бичиг хэрэг, цэвэрлэгээний материалын өр төлбөр үүсгэснээс тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 327,066.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 40,292.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **367,359.6** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 151,065.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 2,584.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 891.0 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг **520,118.2** мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсвийн зохицуулалтаар цалин хөлс, НДШ-ийн зардлыг 13,690.7 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 1,266.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 718.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт **535,793.1** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 488,485.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 40,292.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 6,980.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 35.0 мянган төгрөг нийт **535,793.1** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **428,656.6** мянган төгрөг буюу 80.0 хувьтай байгаа нь хоолны зардлыг 11,022.0 мянган төгрөгөөр, цалин хөлс, НДШ-ийн зардлыг 96,078.0 мянган төгрөгөөр, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн зардлыг 1.5 мянган төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан зардлыг 35.0 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
					Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	71802- Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,088.00	1,086.50	(1.50)	99.8
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	40,196.70	29,174.70	(11,022.00)	72.6
		3	81816- Зөв монгол хүүхэд	2,584.40	2,584.40	-	100.0
		4	81823- Боловсролын багшийн сургалт	1,088.00	1,088.00	-	100.0
		5	81832-Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	5,778.00	5,778.00	-	100.0
		6	81834- Боловсролын стандарт сургалт	321,371.30	246,375.00	(74,996.30)	76.7
		7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	116,378.80	95,297.10	(21,081.70)	81.9
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	40,292.90	40,292.90	0.00	100.0
		9	83602-Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	7,015.00	6,980.00	(35.00)	99.5
<b>Нийт</b>				<b>535,793.10</b>	<b>428,656.60</b>	<b>(107,136.50)</b>	<b>80.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

*/мянган төгрөгөөр /*

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол, бичиг хэрэг	41,009.4	41,009.4	НТШ
	<b>Нийт дүн</b>	<b>41,009.4</b>	<b>41,009.4</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчээр шалгарсан “Өглөг баян” ТББ-тай 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримт бүрэн бүрдүүлсний дараа ажил, гүйлгээг гүйцэтгэж байх, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 362,820.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,628.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сант сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож, 18 мэдээллийг дутуу мэдээлсэн байна. Үүнд:

- Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 1, хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг 18 удаа дутуу мэдээлсэн.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.1, 6.4.5, 6.4.9 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 4,975.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4,975.8	1	4,975.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>4,975.8</b>	<b>1</b>	<b>4,975.8</b>	<b>100</b>

*/мянган төгрөгөөр/*

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах **10,496.0** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6,980.0 мянган төгрөгийн 2 дугаар хоолны тогоо, хандиваар ирсэн 3,516.0 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн байдлын тайланд тусгаж, тайлагнаагүй байна.

Аудитаар нийт **7,663.6** мянган төгрөгийн зөрчил илэрч 1,847.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 5,816.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

##### 5.1 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас бичиг хэрэг, аж ахуйн материалын 1,847.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан хоолны материалын орлогын дүн няравын тайлангаас 2,260.0 мянган төгрөгөөр, зарлагын дүн **2,269.5** мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийг тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үнэдсэлэл болно”, 20

дугаар зүйлийн 20.2 дахь “Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтыг тухай бүр бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

2.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд хүүхдээ асарч байгаа 3 багшийн **1,286.5** мянган төгрөгийн амралтын цалинг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: 2024 оны 1 дүгээр улиралд багтаан нийгмийн даатгалын тайланд нөхөж тайлагнах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгө, бараа материалыг дутуу бүртгэж, тайлагнасан.	1	10,496.0	1	10,496.0			1	10,496.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10,496.0</b>	<b>1</b>	<b>10,496.0</b>			<b>1</b>	<b>10,496.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын өр төлбөр үүсгэсэн.	1	1,847.6			1	1,847.6						
Няравын тайланд хоолны материалын худалдан авалт, зарцуулалтын дүн зөрүүтэй тайлагнасан.	1	4,529.5					1	4,529.5				
Нийгмийн даатгалын тайланд цалин дутуу тайлагнасан.	1	1,286.5					1	1,286.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>7,663.6</b>			<b>1</b>	<b>1,847.6</b>	<b>1</b>	<b>5,816.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 1 мэдээллийг хугацаа хоцроож, 24 мэдээллийг дутуу мэдээлсэн.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>